



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 67


Есөнбулаг сум

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Оюунлаг- Алтай" хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөв, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган батлуулж, биелэлтийн явцыг жил бүрийн IV улиралд багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ



## “ОЮУНЛАГ АЛТАЙ” ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Монголчууд бид оюуны өндөр чадвар, байгалиас заяасан тархины өндөр багтаамж, оюуны их бядаараа дэлхийд цуутай ард түмэн билээ. Тэр дундаа Алтайчууд бид оюуны чадвараараа улсдаа хүлээн зөвшөөрөгдсөн оюунлаг түмэн. Өнөө үед нийгмийн өмнө хурцаар тавигдаж буй нэн тэргүүний шаардлага бол оюунлаг, өөрийн гэсэн үзэл бодол төлөвшсөн, бүтээлч сэтгэхүйтэй иргэнийг төлөвшүүлэхэд оршиж байна.

Бидний ирээдүй болсон хүүхэд багачуудын суурь чадварыг хөгжүүлж, бүтээлч сэтгэхүйтэй, оюунлаг, чадварлаг иргэдийг нийгэмд бэлтгэн гаргах нь үржил шимтэй хөрсөнд үр тариа ургахын адил үр өгөөжөө амархан өгөх ажил болох юм.

Сэтгэх чадварын стандартын сурах бичгээр жилд 200 орчим хүүхэд суралцдаг, шатрын сургалтын тогтсон үйл ажиллагаатай цөөхөн газар 290 хүүхэд суралцдаг, ой тогтоолтын төрлөөр сургалт зохион байгуулагддаггүй нь аймаг орон нутгаас оюунлаг ирээдүйг бэлтгэх нэн тэргүүний шаардлага болж байна.

Монгол Улсын боловсролын хурдацтай хөгжил нь сэтгэхүйн их хурд, ой тогтоолт, бүтээлчээр түргэн сэтгэх, түүний зэрэгцээ багш нараас боловсрол олгох үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, суурь сэтгэлгээ, суурь чадварыг олгох боловсролын стандарт, хөтөлбөр, сурах бичиг, сургалтын орчинг сайжруулах, багшлах боловсон хүчин бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх ажлыг улсын жишигт нийцүүлэх, сэтгэх чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг сайжруулахад байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зэргээр сэтгэлгээ хөгжүүлэх зайлшгүй шаардлагыг үндэслэн энэхүү хөтөлбөрийг боловсруулсан болно.

### Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим:

2.1. Монгол Улсын боловсролын салбарын хөгжлийн бодлого, холбогдох хууль тогтоомж, бусад төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг уялдуулах;

2.2. Сэтгэх чадвар нь боловсрол эзэмших үйл ажиллагааг хурдасгагч, сэтгэлгээний хурдыг нэмэгдүүлэх шаардлагын үндэс болгох;

2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хүн амын боловсролын түвшин, эрэлт хэрэгцээ, сонирхол, боломжид тулгуурлан идэвхжүүлэн чанаржуулах;

2.4. Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь нээлттэй, хүртээмжтэй, уян хатан, чанартай байх, сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургалтын түвшний эрэлт хэрэгцээ, оролцоог хангасан байх.

2.5. Олон улсын болон үндэсний жишигт нийцсэн байх.

### Гурав. Хөтөлбөрийн зорилго:

“Оюунлаг Алтай” хөтөлбөрийн зорилго нь сэтгэлгээний хурдаа нэмэгдүүлж, бүтээлч сэтгэхүйгээ хөгжүүлэх таатай нөхцөлийг хүүхэд багачуудад бүрдүүлэх, Алтайчуудын оюуны төрмөл чадварт тулгуурлан оюуны чадвар, сэтгэлгээний царааг бүтээлч хэлбэрээр хөгжүүлэхэд оршино.

### Хөтөлбөрийн зорилт:

3.1. Оюун ухааныг хөгжүүлэх сургалтын таатай орчинг бүрдүүлэх, багшлах боловсон хүчин, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх.

3.2. Хүүхэд багачуудын оюуны суурь чадварыг хөгжүүлж, бүтээлч сэтгэхүйтэй, оюунлаг чадварлаг иргэнийг нийгэмд бэлтгэх.

3.3. Сэтгэх чадвар, оюуны спортын олон нийтийн арга хэмжээг хөгжүүлэх хамтран туршлага судлах, хувь хүний хөгжлийн хэрэгсэл болгох.

**Дөрөв. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ**

**4.1. Оюун ухааныг хөгжүүлэх сургалтын таатай орчинг бүрдүүлэх, багшлах боловсон хүчин, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх.**

4.1.1. Сургууль, цэцэрлэг бүрт “Оюуны хөгжлийн танхим” байгуулж, үйл ажиллагааг хөгжүүлэх.

4.1.2. Орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, оюуны өмчөөр баталгаажсан сургалтын хэрэглэгдэхүүнээр хангаж шатар, ой тогтоолт, сэтгэх чадварын сургалтыг улсын жишигт нийцэхүйцээр зохион байгуулдаг болох.

4.1.3. Багшлах боловсон хүчний мэргэжил, туршлагыг сайжруулах зорилгоор сэтгэх чадвар, ой тогтоолт, шатрын багш бэлтгэх, багшлах эрх олгох сургалтыг зохион байгуулах.

4.1.4. Оюуны спорт, сэтгэх чадвар, ой тогтоолтын сургалтыг танхимын хэлбэрээс гадна цахим хэлбэрээр зохион байгуулахад шаардлагатай интернэтийг оюун ухааны танхимд ашиглах боломжийг бүрдүүлэх.

4.1.5. Багш нарын бүтээлч оюуныг үнэлэх зорилгоор “Аймгийн бүтээлч багш” уралдааныг батламжлах, шилдэг бүтээлүүдийг олон нийтийн хүртээл болгоход дэмжлэг тусалцаа үзүүлэх

4.1.6. Өөрийн нөхцөл бололцоог ашиглан сурагчдаа чадваржуулж улс бүсэд амжилт гаргасан багш нарын туршлагыг бусдад түгээх урамшуулах.

**4.2. Хүүхэд багачуудын оюуны суурь чадварыг хөгжүүлж, бүтээлч сэтгэхүйтэй, оюунлаг чадварлаг иргэнийг нийгэмд бэлтгэх.**

4.2.1. Орон нутгийн мэдээллийн хэрэгслийг ашиглан сэтгэлгээний чадварыг хөгжүүлэх дасгал, сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, олон нийтэд сурталчлах, тэдний сэтгэлгээний хурд, царааг хөгжүүлэхэд анхаарах.

4.2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах сургалтын орчинг бүрдүүлэхэд орон нутаг дахь төрийн болон төрийн бус байгууллага, ард иргэдийн дэмжлэгийг авах боломжийг бүрдүүлэх.

4.2.3. Хүүхэд багачуудын дунд сэтгэх чадварын их сорилгыг зохион байгуулж, шилдэг үнэлгээтэй сурагчдыг шалгаруулж батламжлах.

4.2.4. Сэтгэх чадвар, шатар, ой тогтоолтын арга техникийг хослуулах аргыг сурагчдад зааж сургах.

4.2.5. Хүүхэд бүрийг шатарчин, даамчин болгох хөдөлгөөн өрнүүлж шатаржуулах.

4.2.6. Шатрын аварга шалгаруулах анги, хамт олон, сургууль, сум, аймгийн хэмжээний тэмцээн зохион байгуулах.

4.2.7. Инженер, техник сэтгэлгээг хөгжүүлэх залуу зохион бүтээгч уралдааныг зохион байгуулах.

4.2.8. Онъсон болон уламжлалт тоглоом, сарабон сампин хөгжүүлэх аян өрнүүлэх.

4.2.9. Оюуны их наадмыг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулж уламжлал болгох.

4.2.10. Ой тогтоолтын аварга шалгаруулах арга хэмжээг зохион байгуулах.

**4.3. Сэтгэх чадвар, оюуны спортын олон нийтийн арга хэмжээг хөгжүүлэх хамтран туршлага судлах, хувь хүний хөгжлийн хэрэгсэл болгох.**

4.3.1. Ард иргэд, олон нийтэд сэтгэх чадвар, ой тогтоолт, шатрын спортыг сурталчлах өдөрлөгийг зохион байгуулж хэвшүүлэх.

4.3.2. Төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах.

4.3.3. Иргэд хөдөлмөрчдийн дунд сэтгэх чадвар, ой тогтоолт, шатрын тэмцээн уралдаан зохион байгуулах.

4.3.4. Шатрын сургуулийн менежментийг сайжруулах, хөгжүүлэх.

4.3.5. Ард иргэд, хүүхэд багачуудад оюуны чадвараа сорих боломж олгох зорилго бүхий цахим хаягийг нээн ажиллуулах.

4.3.6. Шилдэг бүтээлийн үзэсгэлэн яармаг зохион байгуулж бүтээлийг номинаци бүрээр шалгаруулж нийтэд сурталчлах.

**Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, хяналт-шинжилгээ, үнэлгээ:**

**5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа 2017-2020 онд**

**Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт**

6.1. Хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах арга хэмжээг хэрэгжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог хангах хөтөлбөрийн үе шат бүрийн төлөвлөлт хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж ажиллана.

6.2. Хөтөлбөрийг аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сурагч, эцэг эх, эцэг эхийн зөвлөлөөс бүрдсэн ажлын хэсгийг аймаг, сумдад байгуулж ажлын хэсгүүд нь удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллана.

6.3. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулах сургалт, сурталчилгааны ажлын агуулга, арга зүй, төлөвлөгөөг Боловсрол, соёл урлагийн газар боловсруулна.

**Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт:**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 7.1. Улс, орон нутгийн төсөв;
- 7.2. Олон улсын байгууллагын тусламж, хандив, төсөл
- 7.3. Төрийн болон төрийн бус байгууллагын санаачлагаар хуримтлагдсан хөрөнгө;
- 7.4. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө;
- 7.5. Бусад эх үүсвэр.

**Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх**

8.1. Сум бүрийн хөтөлбөр хэрэгжүүлэх салбар хороо, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг хичээлийн жилийн хагас жил тутамд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын зөвлөлд тайлагнаж үнэлүүлнэ.

8.2. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хэсэг хөтөлбөрийн хэрэгжилтийг хичээлийн жилийн төгсгөлд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын зөвлөлд тайлагнаж, үнэлүүлэн үр дүнг тооцон ажиллана.

8.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хариуцна.

8.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, түүний үр дүнгийн талаарх мэдээллийг Боловсрол, соёл, урлагийн газрын цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

8.5. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг улирал бүр нэгж дээр тайлагнан, салбарын хэмжээнд хагас жил тутамд хэлэлцүүлэн тайлагнаж үнэлүүлнэ.

**Ес. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:**

9.1. Хөтөлбөрт хамрагдаж буй хүүхэд багачууд, ард иргэдийн сэтгэлгээний хурд сайжирч, оюуны цараа өргөжин, аливаад бүтээлчээр хандах дадалд суралцана.

9.2. Багшлах боловсон хүчний мэргэжлийн чадварыг орон нутгийн хэмжээнд дээшлүүлэх боломжийг олгож, багш нарын бүтээлч хандлага нэмэгдэнэ.

- 9.3. Боловсролын ажил, үйлчилгээний шинэ дэвшилтэт хэлбэр бий болно;
- 9.4. Сэтгэх чадварын сургалтын хөтөлбөр, сурах бичиг, сургалтын орчин бий болно;
- 9.5. Багш нарын мэргэжлийн ур чадвар дээшилнэ.
- 9.6. Сэтгэх чадвар, ой тогтоолт, шатрын сургалт явуулах багшлах эрхийн сертификаттай багшын тоо нэмэгдэнэ.

**Арав. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт:**

- 10.1. Сэтгэх чадвар, ой тогтоолт, шатар даамны сургалт зохион байгуулах эрх зүй, санхүү, техник технологи, сургалтын таатай орчин бүрдсэн байдал;
- 10.2. Сэтгэх чадвар, ой тогтоолт, шатрын сургалт, агуулга, арга зүй, сургалтын төлөвлөгөө, технологи нэвтэрч хэрэгжсэн байдал;
- 10.3. Орон нутгийн болон улсын хэмжээнд сэтгэх чадвар, ой тогтоолт, шатар даамны чиглэлээр сурагчид, багш нарын гаргасан амжилт бүтээл, урамшуулсан тоо
- 10.4. Сэтгэх чадвар, ой тогтоолт, шатрын клубуудад хичээллэж байгаа суралцагчдын тоон өсөлт
- 10.5. Сэтгэх чадвар, ой тогтоолт, шатрын сургалтын үйл ажиллагаа тогтворжиж, явуулсан сургалт, судалгаа, шинжилгээ, гаргасан эрдэм шинжилгээний бүтээлийн тоо, чанарын өсөлт;
- 10.6. Сургууль, цэцэрлэгт байгуулагдсан сэтгэх чадвар, ой тогтоолт, шатар даамны клубын тоо
- 10.7. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцооны өсөлт;
- 10.8. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан төсвийн хөрөнгө оруулалт, тусламж, хандивын хэмжээ
- 10.9. Клубуудад хэрэглэгдэж буй шатар, даам сэтгэх чадвар, ой тогтоолттой холбогдолтой ном, сэтгүүл, гарын авлага бусад хэрэглэгдэхүүний тоо хэмжээ
- 10.10. Багшлах боловсон хүчнийг бэлтгэх сургалтад хамрагдсан хүний тоо.
- 10.11. Оюуны спорт, сэтгэх чадвар, ой тогтоолтын сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах боломжтой клубын тоон өсөлт.
- 10.12. Цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн сургалт, танин мэдэхүйн чиглэлийн мэдээ мэдээллийн боловсруулалт, тогтвортой байдал, хүртээмж
- 10.13. Сэтгэх чадвар, оюуны спортыг өсвөр үеийнхний дунд түгээн дэлгэрүүлэхэд төрийн байгууллага, хувийн хэвшил, эцэг эхийн оролцоо дэмжлэг нэмэгдсэн байдал.
- 10.14. Хүүхэд багачуудын дунд сэтгэх чадварын сорилгыг зохион байгуулж шилдэг үнэлгээтэй сурагчдыг шалгаруулж батламжлах ажлыг зохион байгуулж хэвших
- 10.15. Сэтгэх чадварын төрөлжсөн олимпиадыг аймгийн хэмжээнд жил бүр нээлттэй зохион байгуулж хэвших
- 10.16. Сэтгэх чадвар, шатар, даамны төрлөөр аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан тэмцээн, оролцогчдын тооны өсөлт.
- 10.17. Бүс, улсын хэмжээнд зохион байгуулагдсан тэмцээн уралдаанд оролцогчдын гаргасан амжилт
- 10.18. Ард иргэд, олон нийтэд сэтгэх чадвар, шатрын спортыг сурталчлах өдөрлөгийг зохион байгуулж хэвшсэн байна.
- 10.19. Оюуны их наадам жил бүр зохион байгуулагдсан байна.
- 10.20. Оюунлаг эмэгтэй, Оюунлаг эрэгтэй, Оюунлаг гэр бүлийг шалгаруулах ажлыг зохион байгуулж шилдгүүдэд батламж олгосон тоо
- 10.21. Ой тогтоолтын аймгийн аварга шалгаруулах арга хэмжээнд оролцогчдын тооны өсөлт
- 10.22. Шилдэг бүтээлийн үзэсгэлэн яармагт оролцогчдын бүтээлийн тоо, чанар, хүртээмж

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр хэмжинэ.

№	Шалгуур үзүүлэлтүүд	Суурь үзүүлэлт	Хүрэх үзүүлэлт		
		2017	2018	2019	2020
1.	Сургууль, цэцэрлэгт байгуулагдсан оюуны хөгжлийн танхимын тоо	0	28	42	56
2.	Сургууль, цэцэрлэгт байгуулагдсан шатрын клубын тоо	7	28	42	56
3.	Оюуны чадвар клубт хичээллэж байгаа суралцагчдын тоон өсөлт	200			
4.	Шатрын клубт хичээллэж байгаа суралцагчийн тооны өсөлт	381	1400	2100	3000
5.	Оюуны чадвар, шатрын хичээл заах сургагч багшийн тоо	7	56	84	112
6.	Шатрын спортын шүүгчийн тоо	1	5	10	20
7.	Шатрын дасгалжуулагчийн тоо	2	28	42	56
8.	Оюуны чадвар, шатрын клубт сэтгэх чадвартай холбогдолтой боловсруулж түгээсэн ном, сэтгүүл, гарын авлага түүний тоо	0	84ш	126ш	168ш
9.	Оюуны чадвар, шатрын спортын сургалтын шилдэг арга зүй технологийг цахим хуудсаар сурталчилсан тоон өсөлт	0	48	96	288
10.	Сургууль, цэцэрлэгт байгуулагдсан оюуны чадвар, шатрын клубын сургалтын орчныг сайжруулах чиглэлээр орон нутаг, хувийн хэвшлийн байгууллага, олон улсын төсөл хөтөлбөрөөс зарцуулсан хөрөнгийн хэмжээ, өсөлт	0	57 сая	21 сая	21 сая
11.	Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан тэмцээнд оролцсон өсвөр үе, насанд хүрэгчдийн тооны өсөлт	360	1400	2100	3000
12.	Шатрын өсвөрийн шигшээ багын тамирчдын тоо /эрэгтэй, эмэгтэй /	12	12	24	36
13.	Сэтгэх чадварын улсын төрөлжсөн олимпиадын амжилт	Алт-1, мөнгө-6 хүрэл-5	1	1	1
14.	Бүс, улсын хэмжээнд зохион байгуулагдсан тэмцээнд оролцсон өсвөр үеийн шигшээ багийн гаргасан амжилт	1 хүрэл, 1 тусгай байр			Алтан медаль
15.	Шилдэг бүтээлийн тоо	0	7	10	17

**“ОЮУНЛАГ АЛТАЙ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
2017-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Үйл ажиллагааны чиглэл	Хүрэх үр дүн	Хугацаа	Хариуцан зохион байгуулах байгууллага	Хариуцах, хамтран зохион байгуулах байгууллага	Зохион байгуулах ажлын тоо	Нэгж арга хэмжээнд зарцуулагдах төсөв /мянган төг/	Төсөв /мянган төг/	Санхүүжилт эх үүсвэр
1	2	3	4	5	6	7	8	9
<b>НЭГ.Оюун ухааныг хөгжүүлэх сургалтын таатай орчинг бүрдүүлэх, багшлах боловсон хүчин, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх.</b>								
1.1. Сургууль, цэцэрлэг бүрт “Оюуны хөгжлийн танхим” байгуулж сэтгэх чадвар, ой тогтоолт, шатрын клуб хичээллүүлэх	Сургууль, цэцэрлэг бүрт оюуны хөгжлийн танхим байгуулагдаж, клубууд хичээллэж хэвшсэн байна.	2017-2018	Сургууль, цэцэрлэг	Сумын ЗД	-	0.5 сая*56	28 сая	ОНТ
1.2. “Оюуны хөгжлийн танхимыг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, тохижуулах /шатар, даам, гарын авлага, ном, дүрст самбар, шоо, хурдан ерөлтийн аяга, оньсон болон уламжлалт тоглоом, сарабон сампин. /	Сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдсан, сургалт зохион байгуулах орчин бүрдсэн байна.	2017, 2018	НБХ, БСУГ	Сургууль, цэцэрлэг	-	1.5 сая*56	60 сая	ОНХС, төсөл хөтөлбөр
							24 сая	төсөл хөтөлбөр
1.3.Сэтгэх чадвар, ой тогтоолт, шатар, даамыг хөгжүүлэх багш нарыг бэлтгэх, чадваржуулах сургалтад хамруулна.	Сургалтад хамрагдсан багш нарын багтай болж хүүхэд хөгжүүлэх бололцоо нөхцөл бүрдсэн байна.	2017, 2019	БСУГ	Сургууль, цэцэрлэг	2	4.5 сая	9 сая	ОНХС
1.4.Сургуулийн оюуны хөгжлийн танхимд интернетийн орчин бүрдүүлнэ	Цахим сургалт зохион байгуулах боломж бүрдэж, нэмэлт хэрэглэгдэхүүнээр хангагдана	2017-2018	Сургууль	БСУГ	1	0.2 сая	5.6 сая	ОНТ
1.5.“Аймгийн бүтээлч багш” уралдааныг зохион байгуулж шилдэг бүтээлийг олон нийтийн хүртээл болгоход дэмжлэг туслалцаа үзүүлэх	Багш нар хүүхэд хөгжүүлэх арга зүй, бүтээлтэй болж сургалтад ашиглаж хэвшинэ.	2018-2020	БСУГ,	НБХ, сургууль, цэцэрлэг	3	1 сая	3 сая	ОНХС
1.6.Улс бүсийн тэмцээнд оролцох баг тамирчдын зардлыг шийдвэрлэх,	Аймаг хотод улс бүсийн чанартай уралдаан тэмцээнд оролцох баг	2017-2020	НБХ	БСУГ	-	2.5	10 сая	ОНХС

101

урамшуулах	тамирчдыг оролцуулсан байна.								
<b>ХОЕР.Хүүхэд багачуудын оюуны суурь чадварыг хөгжүүлж бүтээлч сэтгэхүйтэй, оюунлаг чадварлаг иргэнийг нийгэмд бэлтгэх.</b>									
2.1. Орон нутгийн мэдээллийн хэрэгслийг ашиглан "Оюунлаг Алтай" сургалтын цагтай болж чадварыг хөгжүүлэх дасгал, сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, олон нийтэд сурталчлах	Сургалт сурталчилгаа, арга хэмжээ олон нийтэд мэдээллийн хэрэгслээр хүрдэг болсон байна.	2017-2020	БСУГ	НБХ	-	1 сая	4 сая	ОНХС	
2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах сургалтын орчинг бүрдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, ард иргэдийн дэмжлэгийг авах аян өрнүүлэх	Ард иргэдийн дэмжлэгийг хүртэж хүүхэд хөгжүүлэхэд үр өгөөжтэй ашиглаж хэвшсэн байна.	2017-2020	Сургууль, цэцэрлэг	НБХ, БСУГ	4	-	-	Хандив	
2.3. Хүүхэд багачуудын дунд сэтгэх чадварын их сорилгыг зохион байгуулж шилдэг үнэлгээтэй сурагчдыг батламжлах	Сорилго зохион байгуулагдаж сурагчдыг батламжсан байна.	2017-2020	НБХ, БСУГ	Сургууль, цэцэрлэг	4	0.5 сая	2 сая	Улсын төсөв	
2.4. Нэрэмжит тэмцээн, уралдаан зохион байгуулах олон нийтийн санал санаачлагыг дэмжих	Нэрэмжит уралдаан тэмцээний тоо нэмэгдэж, хамрах хүрээ өргөжсөн байна.	2017-2020	БСУГ	НБХ	-	-	-	Хандив	
2.5. Хүүхэд бүрийг даамчин, шатарчин болгох хөдөлгөөн өрнүүлж шатар, даамжуулах	Айл өрх, хүүхэд бүр насны онцлогоос хамааран шатар, дааманд суралцсан байна, орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих	2017-2018	НБХ, БСУГ	сургууль, цэцэрлэг	-	25.000*560ш	15 сая	ОНХС,	
							15 сая	хандив, төсөл хөтөлбөр	
2.6. Шатрын сургуулийн бүтцийг шинэчилж, аймгийн өсвөрийн шигшээ багийн тамирчдыг бэлтгэх	Сургалтын таатай орчин бүрдэж, өсвөрийн шигшээ багийн тамирчдын бэлтгэл сургалт тогтмолжиж амжилт гарна.	2017-2020	БСУГ	НБХ	-	0.5	2 сая	ОНТ	

202



2.7. Цодгор хүү, өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах	Шатрын аварга шалгаруулах аймгийн тэмцээн зохион байгуулж шалгарсан тамирчид улс бүсийн тэмцээнд оролцсон байна.	2017-2020	Шатрын сургууль	БСУГ, БТСГ	4	0.3 сая	1.2 сая	ОНТ
2.8. Хүүхдийн "Оюуны-Эрэлд" шатрын бага наадам зохион байгуулна	3000 хүүхдийн шатрын өрөг тавьж, багийн тоглолт зохион байгуулж, шилдэг анги, бүлэг, сургууль, цэцэрлэгүүд шалгарсан байна.	2018, 2020	БСУГ, БТСГ, Шатрын сургууль	ЗДТГ	2	2.5 сая	5 сая	ОНХС
2.9. Инженер, техник сэтгэлгээг хөгжүүлэх залуу зохион бүтээгч уралдааныг зохион байгуулах.	Бүтээлч, техник сэтгэлгээтэй хүүхдийг дэмжиж, хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ	2018, 2020	БСУГ	НБХ	2	1 сая	2 сая	ОНХС
2.10. Онъсон болон уламжлалт тоглоом, сарабон сампин хөгжүүлэх аян өрнүүлэх	4-10 насны хүүхдийг хөгжүүлэх сургалт, олон төрлийн уралдаан тэмцээн явагдсан байна.	2017-2020	сургууль, цэцэрлэг	Сумын ЗДТГ, БСУГ	4	1.2 сая	4.8 сая	ОНХС
2.11. Оюуны их наадмыг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулж уламжлал болгох	Сэтгэх чадвар, ой тогтоолт, оюуны тоглоом хөгжиж оюуны их наадам зохион байгуулагдсан байна.	2017-2020	IQ төвийн салбар зөвлөл	НБХ, БСУГ	4	3 сая	10 сая	ОНХС
							2 сая	хандив
2.12. Ой тогтоолтын аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах	Уралдааныг шат дараатай зохион байгуулагдаж, улсын тэмцээнд оролцож амжилт гаргасан байна.	2017-2020	БСУГ	НБХ, сургууль, цэцэрлэг	4	1.2 сая	4.8 сая	ОНХС
2.13. Сурагчдын ХГҮА-ны цагаар сэтгэх чадвар, ой тогтоолт, шатрын сургалтыг зохион байгуулах	Хүүхэд нэг бүр сэтгэх чадвар, ой тогтоолт, шатрын спортоор хичээллэсэн байна.	2017-2020	Сургууль, цэцэрлэг	НБХ, БСУГ	-	-	-	ОНТ
ГУРАВ.Сэтгэх чадвар, оюуны спортын олон нийтийн арга хэмжээг хөгжүүлэх хамтран туршлага судлах, хувь хүний хөгжлийг дэмжих								
3.1. Ард иргэд, олон нийтэд сэтгэх чадвар, ой тогтоолт, шатрын спортыг сурталчлах өдөрлөг зохион байгуулж хэвшүүлэх.	Өдөрлөг зохион байгуулагдаж иргэд олон нийт хамрагдан сурталчлагдсан байна.	2017-2020	БСУГ, Сургууль, цэцэрлэг	НБХ	4	1.5 сая	6 сая	ОНХС
3.2. Төрийн болон	Чөлөөт цагийг зөв	2017-	Сумын Засаг	Төрийн	-	-	-	Улсын

2019

төрийн бус байгууллага бүр оюун ухаанаа хөгжүүлэх цагтай болох	боловсон өнгөрүүлэх боломж нөхцөл бүрдэнэ	2020	дарга, НБХ, БСУГ,	болон төрийн бус байгууллага				төсөв
3.3. Байгууллага, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахдаа сэтгэх чадвар, ой тогтоолт, шатрын төрлөөс 1 арга хэмжээ болгон оруулж байх	Сэтгэх чадвар, ой тогтоолт, шатрыг хөгжүүлэхэд түлхэц болно.	2017-2020	Сумын Засаг дарга, НБХ, БСУГ,	Төрийн болон төрийн бус байгууллага	-	-	-	Улсын төсөв
3.4. Шатрын улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах	Улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаж, тамирчдын ур чадвар сайжирч, материаллаг орчин нэмэгдэнэ.	2019	НБХ	БТСГ, Шатрын сургууль	1	5 сая	5 сая	ОНХС
3.5. Тэмдэглэлт өдрүүдээр Оюунлаг гэр бүл, оюунлаг эмэгтэй, оюунлаг залуу шалгаруулах арга хэмжээг зохион байгуулах	Иргэдэд оюуны үнэт зүйл, сэтгэл зүйн таатай орчин бий болгож, бусдаас суралцах болдмж бүрдэнэ	2017-2020	IQ төвийн салбар зөвлөл	НБХ, БСУГ,	4	0.9 сая	3.6 сая	ОНХС
3.6. Аймаг орон нутгийн албан байгууллага, аж ахуй нэгжийн албан хаагчдын шатрын нөхөрсөг багийн тоглолт зохион байгуулах	Байгууллага хамт олны оюуны хөгжилд ахиц дэвшил гарна	2017-2020	Шатрын сургууль	БСУГ, БТСГ,	4	0.5 сая	2 сая	Хандив
3.7. Ард иргэд, хүүхэд багачуудад оюуны чадвараа сорих боломж олгох зорилго бүхий цахим хаяг, программ ашиглах боломжийг бүрдүүлж ажиллуулах	Бие даан сурч, хөгжих, түвшингээ тодорхойлох боломж бүрдэж цахим хуудастай болсон байна. Цахим хуудсын үйл ажиллагаа тогтмолжсон байна.	2017	Шатрын сургууль, IQ төвийн салбар зөвлөл	НБХ, БСУГ	-	0.5 сая	0.5 сая	Улсын төсөв
3.8. Шилдэг бүтээлийн үзэсгэлэн яармаг зохион байгуулж бүтээлийг номинац бүрээр шалгаруулж нийтэд сурталчлах	Үзэсгэлэн яармаг зохион байгуулагдаж хөгжих боломж бүрдсэн байна.	2018, 2020	НБХ	БСУГ	2	2 сая	4 сая	ОНХС
2017-2020 онд хөтөлбөр хэрэгжүүлэх нийт төсөв							228.5	
ОНХС							146.2	
Хандив, төсөл хөтөлбөр							43	

1490

Орон нутгийн төсөв	36.8	
Улсын төсөв	2.5	

Төсвийн задаргаа

/ Сая, төгрөгөөр /

№	Эх үүсвэр	2017 он	2018 он	2019 он	2020 он	Нийт
1	ОНХС	41.3	66.3	21.3	17.3	146.2
2	Хандив, төсөл хөтөлбөр	20.5	20.5	1.0	1.0	43
3	Орон нутгийн төсөв	17.6	17.6	0.8	0.8	36.8
4	Улсын төсөв	1	0.5	0.5	0.5	2.5
5	Нийт	80.4	104.9	23.6	19.6	228.5

-----000-----

285